



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/389

Мандалговь

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.3 заалт, Аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дүгээр захирамжаар батлагдсан "Урамшуулалын жишиг тогтоох журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2 дах заалт, Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайхан-Овоо сумын уугуул Норпилын Чагнаа нь Монгол Улсын Байгаль орчны "Гавьяат ажилтан" цол хүртсэн тус Аймгийн "Хүндэт өргөмжлөл" мөнгөн урамшуулал олгосугай.

Хоёр. Урамшуулалд шаардагдах 400,000 (дөрвөн зуун мянга), Хүндэт өргөмжлөл хэвлүүлэхэд 35000 (гучин таван мянга), нийт 435000 (дөрвөн зуун гучин таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010252